

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багахангай үйлдвэрлэл технологийн парк ХК-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/077/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г. Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 9909-9119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Компани /ТӨҮГ/, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 819

танай _____-ны № _____-т

“БАГАХАНГАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ЗАХИРАЛ Ц.ЖАМБАЛЦЭРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн өмчит Багахангай үйлдвэр технологийн парк ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 30.5 сая төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн 1/011 дүгээр тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин баталсан байна. Өөрийн үйл ажиллагааны болон бусад орлогын эх үүсвэр байхгүй тул тайлант онд дүрмийн санг нэмэгдүүлсэн орлогоор санхүүжиж, нийт зардлыг 700.0 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр санхүүжилт 700.0 сая төгрөг, хүүгийн орлого 1.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 633.6 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

1426050875

C:\Users\narangua\Desktop\Бичир хэргийг 2026\2026\word\wordywan bichig\Dugnet_2026.docx

Аудитын гол асуудал

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/114 дүгээр захирамжаар Багахангай үйлдвэр технологийн парк ХК-ийн дүрмийн санг 700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, санхүүжилт олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		67,856,976.94
Дансны авлага		75,670.02
Урьдчилж гарсан зардал		969,444.00
Бараа материал	6,005,760.00	7,417,130.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,005,760.00	76,319,220.96
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	16,349,280.35	25,408,427.04
Биет бус хөрөнгө	969,882,082.49	1,135,192,012.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	986,231,362.84	1,160,600,439.04
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	992,237,122.84	1,236,919,660.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг		103,200.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.00	103,200.00
Өр төлбөрийн нийт дүн	0.00	103,200.00
Эздийн өмч		
Өмч:-төрийн		
- хувьцаат		1,352,600,000.00
Хуримтлагдсан ашиг	992,237,122.84	(115,783,540.00)
Тайлант үеийн үр дүн		
Эздийн өмчийн дүн	992,237,122.84	1,236,816,460.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	992,237,122.84	1,236,919,660.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны орлого		
6	Бусад орлого	695,779,331.27	197,473,338.97
7	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	364,470,364.38	652,745,947.51
9	Санхүүгийн зардал		148,054.30
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	331,308,966.89	(455,420,662.84)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	331,308,966.89	(455,420,662.84)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	331,308,966.89	(455,420,662.84)
24	Орлогын нийт дүн	331,308,966.89	(455,420,662.84)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	354,929,615.27	700,000,000.00
1.1.5	Татаас, санхүүгийн орлого	-	700,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	354,929,615.27	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	354,929,615.27	618,648,166.03
1.2.1	Ажиллагчдад төлсөн	295,248,212.11	415,305,178.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	36,226,599.16	117,093,443.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,541,400.00	10,048,920.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,485,364.00	11,653,808.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	6,558,300.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	34,712,076.65
1.2.10	Бусад мөнгөн зарлага	4,428,040.00	23,276,440.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,427,996.00	81,351,833.97
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,480,542.97
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	1,480,542.97
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	14,995,600.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	14,995,600.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(13,515,057.03)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	20,200.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	20,200.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	20,200.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,427,996.00	67,856,976.94
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	67,856,976.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл				

Багахангай үйлдвэрлэл технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	660,928,155.95	660,928,155.95
3	Залруулсан үлдэгдэл			660,928,155.95	660,928,155.95
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	331,308,966.89	331,308,966.89
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл			992,237,122.84	992,237,122.84
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(652,600,000.00)	(652,600,000.00)
11	Залруулсан үлдэгдэл			339,637,122.84	339,637,122.84
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(455,420,662.84)	(455,420,662.84)
14	Өмчид гарсан өөрчлөлт	1,352,600,000.00			1,352,600,000.00
17	2025 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,352,600,000.00		(115,783,540.00)	1,236,816,460.00

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Биелэлт хувь	Зөрүү
1. Нийт орлого		700,000,000.00	701,500,742.97	100.0%	
1.1	Нийслэлийн төсвөөс	700,000,000.00	700,000,000.00	100.0%	
1.2	Хүүний орлого		1,480,542.97	100.0%	
1.3	Дансны эхний үлдэгдэл		20,200.00	100.0%	
2. Нийт зардал		700,000,000.00	633,643,766.03	88.9%	67,856,976.94
2.1	ТУЗ-ийн урамшуулал	82,232,000	82,232,000	100.0%	-
2.2	ТУЗ-ын ндш /байгууллагаас төлөх/	9,867,840	9,867,840	100.0%	-
2.3	ТУЗ-ын хуралдааны зардал	4,000,000	3,491,500	87.2%	508,500
2.4	Үндсэн цалин, нэмэгдэл хоол унаа	423,000,000	423,634,925	100.1%	(634,925)
2.5	НДШ /байгууллагаас төлөх/	52,113,496	51,063,933	97.9%	1,049,563
2.6	Утас интернет, шуудангийн зардал	1,474,800	1,199,000	81.3	275,800
2.7	Байрны түрээс, ашиглалт	9,485,364	10,454,808	110.2%	(969,444)
2.8	Хангамж /бичиг хэрэг, аж ахуйн материал/	7,057,400	7,057,420	100.1%	(20)
2.9	Шатахууны зардал	7,000,000	6,558,300	93.7%	441,700
2.10.	Бусад зардал	84,742,600	19,852,040	23.4%	64,890,560
2.11	Урсгал засвар	15,800,000	15,755,500	99.7%	44,500
2.12	Программ хангамж	1,726,500	1,726,500	100%	-
2.13	Нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулал	1,500,000	750,000	50%	750,000
3. Дансан дах үлдэгдэл		0.00	67,856,976.94		67,856,976.94

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30,560.0 мянгантөгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 зөвлөмжийг хүргүүлж байна.

Нийт залруулагдаагүй 30,560.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тооцсон 7,015.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 30,560.0 мянган төгрөгийг тайлант оны зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг данс бүртгэлд үнэн зөв хөтлөж, тайлагнаж байх;

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлийг буруу бүртгэсэн	1	30,560.0					1	30,560.0
Дүн	1	30,560.0					1	30,560.0

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

